

**Хувилбар нэр томъёоны асуудалд
(стандартчилсан нэр томъёоны жишээгээр)**

ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ӨГҮҮЛЭЛ

Нарангийн АМАРТҮВШИН*

*Монгол Улс, Улаанбаатар, Шинжлэх Ухааны Академийн Хэл зохиолын
хүрээлэнгийн Хэрэглээний хэл шинжлэлийн салбар*

Received: June 23, 2024

Revised: September 20, 2024

Accepted: October 25, 2024

Хураангуй: Монгол Улсад нэр томъёоны байгууллага 1924 оны 3 сарын 28-нд Улсын Нэр Томъёоны Комисс (УНТК) нэртэйгээр байгуулагдан тэр цагаас шинжлэх ухааны салбар бүрийн нэр томъёог оноон боловсруулж ирсэн. Энэ комисс мэргэжлийн салбаруудын хүрээнд дагаж, мөрдөх бүх нэр томъёог эрдэм шинжилгээний үндэстэйгээр боловсруулан баталж, түүнийг нийтээр журамлах ажлыг эрхлэн явуулж ирсэн бөгөөд үйл ажиллагаа нь зогсож, завсарлан мөн дахиж сэргэсэн хугацаатайгаа эдүгээ 100 дахь жилээ угтаж байна. 20-р зууны эхэн үеэс орчин цагийн шинжлэх ухааны шинэ ухагдахуунуудыг илэрхийлсэн нэр томъёо голдуу Европын хэлнүүдээс монгол нэр томъёоны тогтолцоонд орж ирснээр Монгол Улсад орчин цагийн нэр томъёо судлалын үйл ажиллагаа эхэлжээ.

Монгол Улсын шинжлэх ухаан, мэргэжлийн салбарт шинээр орж ирсэн ухагдахууныг илэрхийлсэн гадаад нэр томъёог монгол хэлнээ орчуулах, монголоор нэрлэх, нэр томъёо тогтоох үйл явцад нэг ухагдахууныг олон янзаар буюу хоёроос дээш нэр томъёогоор илэрхийлсэн хувилбар үүсэн олиширноос одоо ч нэг мөр тогтоож журамлагдаагүй нэр томъёо олон байна. Эдгээр нь хэрэглээнд нэвтэрсэн эхэн үедээ хамтаар хэрэглэгдэж болох ч цаг хугацааны явцад хувилбараас журамласан нэг нэр томъёо болох ёстой.

Сүүлийн жилүүдэд орчин цагийн шинжлэх ухаан, эдийн засгийн хөгжил нь хэрэглэгчийн байр сууринаас бүтээгчийн байр сууринд хүргэсэн Азийн зарим улсаас орж ирж буй аж үйлдвэр, ахуй, хүнс, соёлын бүтээгдэхүүн, үйлчилгээ тэдгээрийн хэрэглээ, технологийг дагалдсан нэр томъёо монгол хэлэнд орж ирэн хувилбар үүсгэж эхэлжээ. Өнөө цагт шинжлэх ухааны үндэстэй боловсруулан

* © Н.Амартүвшин, 2024

Email: amartuvshin@mas.ac.mn,  <https://orcid.org/0009-0004-2493-8041>

тогтоож, журамлан батлаагүй нэр томъёог MNS стандарт болгон бүртгээж байгаа нь учир дутагдалтай юм.

ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнгийн Хэрэглээний хэл шинжлэлийн салбар, Хэлний бодлогын үндэсний зөвлөлийн Ажлын албатай хамтран Монгол Улсын аж үйлдвэр, нийтлэг үйлчилгээний салбарын 85 нэр томъёоны стандартын 10387 нэр томъёогоор хөмрөг бүрдүүлснээ энэхүү өгүүлэлд судалгааны хэрэглэгдэхүүн болгон ашиглав. Хөмрөгөөс нэг ухагдахууныг олон янзаар нэрлэсэн буюу хоёроос дээш нэр томъёогоор тогтоож нэрлэсэн хувилбар нэр томъёог ялган авч тэдгээрээс зөв хувилбарыг сонгох, гадаад үгээс бүрдсэн хувилбарыг орчуулах, тэдгээрийг жигдлэх, стандартчилах, журамлах талаар өөрийн саналыг дэвшүүлсэн болно.

Түлхүүр үгс: Хувилбар нэр томъёо, нэр томъёоны стандарт, нэр томъёо журамлах, нэр томъёо жигдлэх, нэр томъёо стандартчилах

Issue of variant terms (example of standardized terms)

AMARTUVSHIN Naran

Department of Applied Linguistics, Institute of Language and Literature, Mongolian Academy of Sciences, Ulaanbaatar, Mongolia

Abstract: *In Mongolia, the terminology organization was established on March 28, 1924, under the name of the State Commission for Terminology (SCT). It has been responsible for the general regulation of terminology, though its activities have been interrupted and resumed at various points. Now, it is celebrating its 100th anniversary. Since the early 20th century, terms expressing new concepts in modern science, primarily borrowed from European languages, have entered the Mongolian terminology system, marking the beginning of modern terminology activities in the country. During the translation of foreign terms representing newly introduced scientific and professional concepts into Mongolian, the same concept was often expressed in multiple ways or with more than one term. Initially, these variant terms were used, but as time passed and the terms were standardized, efforts to regulate them as official terms began.*

In recent years, the rapid development of modern science and the economy has shifted Mongolia's role from a consumer to a creator. As a result, terms related to industrial, household, food, and cultural products, as well as services, have entered the Mongolian language from certain Asian countries. These terms have created variants that accompany their use and technology. Currently, it is problematic that the Mongolian Agency for Standardization and Metrology registers terms that have not been processed or officially approved by an authorized research organization.

The Department of Applied Linguistics at the Institute of Language and Literature, Mongolian Academy of Sciences in collaboration with the Office of the National

Council for Language Policy created a corpus consisting of 10,387 terms from 85 terminology standards. This corpus serves as the research material for this article. From this, we selected variant terms that express the same concept in different ways and propose recommendations for their harmonization, standardization, and regulation.

Keywords: *variant terms, terminology standards, harmonization of terms, standardization of terms*

1. Удиртгал

Дэлхийн улс орнуудын хэлний хэрэглээнд шинжлэх ухааны ухагдахууныг олон янзаар нэрлэх үзэгдэл түгээмэл байдаг. Энэ нь олон нийтийн хэлний хэрэглээгээр тогтохгүй цаашлаад тухайн хэлний мэргэжлийн салбарын нэр томъёоны тогтолцоонд нэг ухагдахууныг хоёроос дээш буюу олон нэр томъёогоор илэрхийлэх байдлыг бий болгодог. Шинжлэх ухаан өндөр хөгжсөн, нэр томъёоны тогтолцоо нь жигдэрсэн улсад энэ үзэгдэл бага байдаг бол харин “орчин үеийн шинжлэх ухаан”-ыг (Европт “сэргэн мандалтын үе” хэмээх XV-XVI зуунд эхлэн түүнийг залгаад “гэгээрлийн үе” гэдэг XVII-XVIII зуунд эрчимтэй хөгжсөн шинжлэх ухааныг “орчин үеийн шинжлэх ухаан” гэдэг. Энэ нь эдүгээ дэлхийн нийтийн шинжлэх ухаан, технологи, урлаг, боловсрол, соёл цаашлаад аж үйлдвэржилтийн хувьсгал, орчин цагийн амьдралын хэв маягийн суурь үндэс болсон ажээ) гаднаас нэвтрүүлсэн улс, үндэстний хэлний хэрэглээнд элбэг байна. Энэ нь Ази, Африк, Зүүн Европын улс орнуудын шинжлэх ухаанд эртний латин, грек улмаар наашлаад герман, франц, англи хэлний үгсээс гаралтай нэр томъёо элбэг байдгийн уг шалтгаан болдог.

Эдгээр улс бас дотроо “шинжлэх ухаан өндөр хөгжсөн”, “буурай хөгжилтэй буюу хөгжөөгүй” эсвэл “хөгжиж байгаа” гэж хуваагдах бөгөөд шинжлэх ухаан өндөр хөгжсөн эсвэл буурай хэсэгт нь нэр томъёоны хувилбар үүсэх үзэгдэл бага бол шинжлэх ухаан ид хөгжиж байгаад нь их байдаг. “Шинжлэх ухаан өндөр хөгжсөн” хэсэг нь үйлдвэрлэгч, бүтээгч улсын эгнээнд шилжсэнээр эргээд өөрсдөө шинжлэх ухаан, соёлын экспортлогч болдог учраас нэр томъёоны хувилбар үүсэх байдал багассан бол “буурай хөгжилтэй” хэсэгт нь гаднаас шинэ ухагдахуун нэвтрэх нь удаан байдагтай холбоотой. Харин “шинжлэх ухаан хөгжиж байгаа” гэх улсуудын хэлний хэрэглээнд гаднаас шинэ ухагдахуун тасралтгүй, эрчимтэй орж ирдэг нь гадаад үгийн хэрэглээ, орчуулгаас шалтгаалсан хувилбар нэр томъёо их үүсэх шалтгаан болдог билээ.

Монгол Улс шинжлэх ухаан хөгжиж байгаа улсын эгнээнд багтана. Мөн шинэ мэдлэг бүтээгч улсаас хэрэглэгч улсад очдог зүй тогтлын дагуу манай улсын шинжлэх ухаан, технологи, соёл, мэргэжлийн салбаруудад шинэ мэдлэг ихэвчлэн гаднаас орж ирдэг. Улмаар тэдгээрийг илэрхийлдэг гадаад үгээс бүтсэн нэр томъёо, монгол үгээр оноосонтой хувилбарлах үзэгдэл XX зууны эхэн үеэс элбэгшиж энэ байдал одоо ч хэвээр үргэлжилсээр байгаа билээ. Энэ үйл явц

эхнээсээ ихэвчлэн Европын хэлнүүдээс гадаад нэр томьёо монгол нэр томьёоны тогтолцоонд орж ирэн хувилбар үүсгэх хэлбэрээр өрнөж байсан бол эдүгээ орчин цагийн шинжлэх ухаан хөгжихийн хэрээр улс нь хэрэглэгчийн байр сууринаас бүтээгч орны байр сууринд шилжсэн Азийн зарим улсаас орж ирж буй аж үйлдвэр, ахуй, хүнс, соёлын бүтээгдэхүүн, үйлчилгээ тэдгээрийн хэрэглээ, технологийг дагалдсан нэр томьёоны хувилбар үүсэх шинэ нөхцөл байдал ажиглагдаж эхэлж байна.

Нэр томьёоны хувилбар бий болох үзэгдэл хэрэглэгч улсаас бүтээгч улс болсон цагт л багасах бичигдээгүй хуультай. Тэр болтол монгол хэл шинжлэлд тулгамдаж буй энэ асуудлыг нэр томьёо судлалыг хөгжүүлэх, нэр томьёог стандартчилах, жигдрүүлэх, журамлах цаашлаад хууль эрх зүйн орчныг бүрдүүлэх байдлаар асуудлыг шийдэх боломжтой юм. Энэ нь “language planning” буюу “хэл төлөвлөлт”-ийн гол гурван зарчмын нэг “corpus planning”-д хамаарах бөгөөд “хэл төлөвлөлт” гэдэг нь урсгалаараа өөрчлөгдөж буй хэлний хөгжилд хууль эрх зүйн орчныг бүрдүүлэх замаар зориудаар нөлөөлөх үйл явцыг хэлдэг билээ.

Нэг ухагдахууныг нэг хэлэнд хоёроос дээш нэр томьёогоор нэрлэх энэхүү үзэгдлийг дараах байдлаар тодорхойлжээ. Нэр томьёоны олон улсын стандарт ISO 860: 2007-д “Нэг ухагдахууныг нэг хэлэнд олон нэр томьёогоор тэмдэглэх” (ISO 860: 2007) хэмээн тодорхойлсон байдаг. Хэл шинжлэлч Мелания Гарсиа¹, Пилар Араус² нар “Ижил ухагдахууныг өөр өөрөөр нэрлэхэд хувилбар нэр томьёо үүсдэг” (2020:) гэсэн бол нэр томьёо судлаач Мигуэль Мора³, Мария Пастор⁴ нар “Хувилбар нэр томьёо гэж нэг ухагдахууныг нэрлэсэн нэг хэлний нэр томьёонууд юм. Энгийн нэр томьёо нь үглэвэр (лексем) болон түүний утгын дүйцлээс бүтэх бол хувилбар нэр томьёо стандартчиллын явцад ойролцоо нэрээс үүсэн гарч ирдэг” (2012:) хэмээжээ. Ц.Өнөрбаян “Хос нэр томьёо гэдэг нь нэг ухагдахууныг тэмдэглэсэн хоёр ба түүнээс дээш нэр томьёо юм” (Өнөрбаян, 1999). “Ойролцоо нэр, орлох нэр хоёрын гол ялгаа нь гэвэл ойролцоо нэр бие биеэсээ утга, эсвэл сэтгэл хөдлөл, эсвэл найруулгын нарийн өнгө аясаар ялгардаг бол орлох нэрд тийм ялгаа байдаггүй, шинжлэх ухааны ухагдахууныг өөр өөр үгээр нэрлэдэг” (Адьяа, 2000) гэжээ.

Монгол нэр томьёо судлалд дээрх ухагдахууныг “орлох нэр” (Адьяа, 2000; Болд, 2009; Бямбажав, 2020), “хос нэр томьёо” (Өнөрбаян., Надмид, 1999; Балдан, 2000), “дублет” (Болд, 2009), “хувилбар нэр томьёо” (Мөнхцэцэг, 2020), “үнэмлэхүй ойролцоо нэр” (Төмөрцэрэн, 1974) гэх мэт олон янзаар нэрлэжээ.

Н. Мөнхцэцэг “Нэр томьёоны орчуулга судлал” номдоо:

“Ийм төрлийн нэр томьёог монгол хэл шинжлэл, нэр томьёо судлалд янз бүрээр нэрлэсээр иржээ. Тухайлбал “хос нэр томьёо” (Бертагаев, 1971; Өнөрбаян, Надмид., 1998); “хос нэрлэлт”, “хос нэр”, “хос

¹ Melania Cabezas-García

² Pilar León Araúz

³ Miguel Ángel Candel Mora

⁴ María Luisa Carrió Pastor

нэришилт үг” (Туул, 2004; Чулуунбат, 2009;), “орлох нэр” (Адъяа, 2000; Чулуунбат, 2009; Гэрэлмаа, 2011; Болд, Шинэбаяр, 2012; Бямбажав, 2019), “дублет” (Болд, 2000; Гэрэлмаа, 2011) гэх мэт. Дээрх судлаачдын нэрлэлтийг дүгнэн үзвэл, тэдгээр олон хувилбарт нэр томъёог “хос нэр” хэмээн нэрлэх нь учир дутагдалтай. Учир нь ийм төрлийн нэр томъёо хоёр ба түүнээс дээш олон хувилбартай байна. Мөн “орлох нэр” гэдэг нь цаад санаа буюу зорьсон санааны хувьд байх ёстой үзэгдэл мэт ойлгогдож байгаа тул тухайн ухагдахууныг ийнхүү нэрлэх нь нэр томъёо ганц утгатай байх гэсэн зарчимд нийцэхгүй. Харин “хувилбар нэр томъёо” гэвэл утга хэрэглээний хувьд бусад нэр томъёог бодвол илүү тохиромжтой гэж үзэж байна. “Хувилбар” гэдэг үгийг Монгол хэлний их тайлбар тольд “Нөхцөл байдал, баримтыг тайлбарлах нэгэн зүйл ялгаа” хэмээн тодорхойлсон байна. Тиймээс тухайн үзэгдлийг “хувилбар нэр томъёо” (цаашид ийнхүү) гэж оноох нь илүү оновчтой мэт санагдана” (Мөнхцэцэг, 2020) гэжээ.

Олон улсад уг нэр томъёог “*term variation*” гэж жигдлэн тогтоожээ. Жишээ нь нэр томъёоны олон улсын стандарт ISO 860: 2007-д “*term variation*” (ISO 860: 2007; Мелания Гарсиа, Пилар Араус нар, 2020; Мигуэль Мора, Мария Пастор нар, 2012) Харин цөөн тохиолдолд “*term variants*” (Биатрис⁵ нар 2000) гэж нэрлэх нь тохиолддог.

Олон улсад хэл шинжлэлчид хувилбар нэр томъёог үг зүй талаас нь “absolute synonym”, “exact synonym”, “perfect synonym”, “total synonym”, “complete synonym” гэж нэрлэх нь элбэг. Монгол хэл шинжлэлд үүнийг “үнэмлэхүй ойролцоо нэр”, “туйлын синоним”, “үнэмлэхүй синоним” гэх мэтээр орчуулан хэрэглэж иржээ.

“Нэр томъёоны системд ойролцоо утгатай нэр томъёо байдаггүй боловч нэг ухагдахууныг тэмдэглэсэн хоёроос дээш (хэл шинжлэлд “туйлын синоним” гэж нэрлэдэг) нэр томъёо байдаг” (Өнөрбаян, 1999) гэсэн бол Ж.Төмөрцэрэн “Ойролцоо нэр нь дотроо хэд хэдэн зүйлийн ялгагдах онцлогтой байдаг. Эдгээрийн дотроос анхаарал татах зүйлийн нэг нь “үнэмлэхүй ойролцоо нэр” болно” (Төмөрцэрэн, 1974) гээд эдгээр үгийг жишээ болгожээ.

- Адрес - хаяг
- Эмийн сан – аптека
- Гүн ухаан – философи
- Цонх- гэгээвч
- Бичил хороолол - микро район
- Хими- хувилах ухаан

Эдгээр нь нэг ухагдахууныг нэрлэж байгаа учраас хувилбар нэр томъёо мөн болно. Хэл шинжлэлчид “absolute synonym”-ийн талаар маргаантай байр суурьтай байдаг. “Үнэмлэхүй ойролцоо нэр нь үг зүйн хувьд ижил утгатай”

⁵ B'eatrice Daille

(Лионс⁶, 1977). “Үнэмлэхүй ойролцоо нэрийг бүх төрлийн бичвэрт харилцан орлуулахад утга алдагдахгүй” (Тодд⁷, 1989: 81) гэж зарим нь үзэцгээдэг бол “Үнэмлэхүй ойролцоо нэр байх боломжтой боловч ховор тохиолдоно. Энэ нь тодорхой нөхцөл, цаг хугацаанд л оршдог” (Финч⁸, 1999: 149) гэсэн байна.

2. Судалгааны арга зүй

Хувилбар нэр томьёо үүсэх шалтгаан түүнд хандах хэл шинжлэлчдийн үзэл баримтлал, тодорхойлолт, тэдний судалгааг онол, практикийн үүднээс харьцуулалт хийх, тоочин дүгнэх аргуудыг хэрэглэв. Улмаар Стандарт, хэмжил зүйн газрын өгөгдлийн сангаас 85 стандартын 10387 нэр томьёо бүхий хөмрөг бүрдүүлэн эндээс түүвэрлэн ангилах аргаар нэг ухагдахууныг хоёроос дээш нэр томьёогоор оноосон хувилбар нэр томьёог ялган тэдгээрээс зөв хувилбарыг сонгох, жигдлэх, стандартчилах, журамлах, гадаад үгээс бүрдсэн хувилбарыг орчуулах талаар өөрийн саналыг дэвшүүлсэн болно. Чингэхдээ хувилбар нэр томьёог нэг хэлний болон хоёр хэлний хувилбараар нь ялган жагсаан хүснэгтлээд харьцуулах, тоочих, орчуулах аргуудыг хэрэглэн жишээ баримтаар өгүүлэв.

3. Монгол хувилбар нэр томьёоны тухай судлаачдын санал

Монгол нэр томьёоны тогтолцоонд хувилбар нэр томьёо байх нь зөв эсэх талаарх эрдэмтэн, судлаачдын саналыг ангилвал:

1. а) Ш. Лувсанвандан “*Харь хэлнээс зээлдэн авсан нэр томьёонд давхар монгол нэр томьёо тогтооход уул харь хэлний нэр томьёог олон түмэнд өргөн дэлгэрүүлэх, тухайн нэр томьёогоор илэрсэн ухагдахууныг хүнд гүнзгий ойлгуулахад их тустай бөгөөд харь хэлнээс зээлдэн авсан үгсийг монголоор хэлбэл ингэсэн үг гэж хосолсон нэр томьёог зүүж өгөх хэрэг гарна*” (Лувсанвандан, 1962), Ц. Дамдинсүрэн “Нэр томьёоны талаар орчуулж болохуйцыг орчуулах, болохгүйг хэвээр хэрэглэх, хослон хэрэглэх гурван аргыг баримтална” (Балдан, 2002) гэжээ.

б) Орчин цагийн хэл шинжлэлчдээс Л. Болд “Нэр томьёо, тэр дундаа техник, технологийн нэр томьёо нь монгол хэлний хувьд шинээр бүрэлдэн бий болж байгаа учир орлох нэр /дублет/ гарах нь зүй ёсны хэрэг... адил утга илэрхийлж буй үгийг хослуулан оруулсныг хувьдаа буруушаахгүй” (Болд, 2009) мөн бас “Өнөөдрийн байдлаар үзвэл монгол нэр томьёо бүрэлдэх шатандаа яваа учир бидний оролцоотой болон оролцоогүй боловсруулсан нэр томьёо тэр бүр амжилттай болж чадахгүй, нэр томьёоны хувилбар гарах, тогтоосон нэр томьёо амьдралд тэр бүр нийцэхгүй байх явдал тохиолдсоор л байна” (Болд, 2001), Г. Томтогтох “Нэр томьёоны хэд хэдэн хувилбар хэрэглэгдэж байгаа нь зөв, тохирох нэр томьёо хайж олох сонголт явагдаж байгааг гэрчилнэ” (Томтогтох, 2014) гэж нэр томьёо хувилбарлах үзэгдлийг байх ёстой хэмээн үзэцгээжээ.

⁶ John Lyons

⁷ Loreto Todd

⁸ Geoffrey Finch

2. Ц. Өнөрбаян “Хос нэр томъёо хэлний цэгцэд харштай. Нэр томъёо журамлагдахын хэрээр хос нэр томъёо цөөрнө” (Өнөрбаян, 1999), Э. Пүрэвжав “Гадаад хэлний нэг нэр томъёог монголчлохдоо ойролцоо утгатай өөр өөр үгээр оноон орчуулах нь монгол хэлний хэм хэмжээнд харшилна” (Пүрэвжав, 1996), Н. Мөнхцэцэг “Нэг ухагдахууныг олон хувилбартай оноох нь шинжлэх ухааны салбарын харилцаанд төдийгүй нийгмийн харилцаанд сөргөөр нөлөөлөх, төөрөгдөл үүсгэж болох тул ийм үзэгдэл үүсэх хэлний болоод хэлний бус шалтгааныг арилгах нь зайлшгүй чухал юм” (Мөнхцэцэг, 2020) хэмээн эдгээр судлаач эсрэг байр суурьтай байна.

3. С. Энхжаргал “Мэдээлэл зүйн хичээлийн сурах бичигт информатикийн зарим түгээмэл бус нэр томъёог оруулахдаа...гэх мэтээр монгол хэлээр оноосон хувилбартай нь хамт бичсэн нь сурагчдад ойлгомжтой болсны дээр нэр томъёо жигдэрч, хэрэглээнд хэвшихэд тустай байж болох юм” гээд нөгөөтээгүүр “шинээр үзэж буй ухагдахууны гадаад нэр томъёог нэгэнт танилцуулсан бол дараагийн удаад монгол хэлнийхээ оноосон үгээр хэрэглэвэл нэр томъёог хэвшүүлэхэд тус дөхөмтэй юм” (Энхжаргал, 2014) гэжээ.

1 болон 3-ын хэл шинжлэлчдийн үзэл баримтлал бүгд хоёр хэлний буюу гадаад-монгол хувилбарт холбогдох бол 2-ын хэл шинжлэлчдийн саналууд монгол, гадаад-монгол хувилбар нэр томъёонд хоёуланд нь хамаарна. Иймээс хувилбар нэр томъёог дэмжсэн хэл шинжлэлчдийн байр суурь зөвхөн монгол оноолтыг гадаад хувилбартай хамт хэрэглэхийг буюу гадаад-монгол хувилбар нэр томъёонд хамаарах бөгөөд гадаад нэр томъёог монгол хэлээр оноохдоо олон хувилбар үүсгэхийг дэмжсэн хэл шинжлэлч байхгүй гэж үзэж болохоор байна.

Нэг хэлнээс нөгөөд орж ирж буй гадаад нэр томъёо тухайн улс, үндэстний хувьд шинэ, урьд өмнө нь байгаагүй эсвэл мартагдсан ухагдахууныг нэрлэсэн байдгаас энэхүү ухагдахуунтай хүмүүс танилцах, оноосон нэр томъёо нь хэлний хэрэглээнд хэвших хүртэл буюу өөрөөр хэлбэл тодорхой нөхцөлд, тодорхой хугацаагаар монгол нэр томъёог гадаад хувилбартай нь давхар хэрэглэж болох ч нэр томъёоны ердийн үгээс ялгарах гол шинж болох ганц утгатай байх, нэг ухагдахууныг илэрхийлэх гэсэн шаардлагын үүднээс эцэст нь зайлшгүй тогтсон нэг хувилбарыг сонгон журамлах ёстой гэж үзэж байна.

2007 онд шинэчлэн хэвлэгдсэн нэр томъёоны олон улсын стандарт ISO 860:2007(E) дээр хувилбар нэр томъёо үүсэх үндсэн шалтгааныг дараах байдлаар ангилжээ. Үүнд:

1. Газар зүйн байрлалаас хамаарсан хувилбар
2. Дуудлагын хувилбар
3. Регистр буюу хам орчны хувилбар
4. Найруулгын хувилбар (ISO 860:2007(E))

Газар зүйн хувилбар гэдэг нь нэг хэлт улс орнууд нэг ухагдахууныг өөрийн газар нутагт ялгаатай нэрлэх явдал юм. Тухайлбал, Их Британи Умард Ирландын Нэгдсэн Вант Улс, Ирланд, Австралид цахилгаан шатыг “lift” /Америкийн

Нэгдсэн Улс, Канадад “elevator” гэдэг бол дуудлагын хувилбар нь нэг хэлт улс орнууд нутгийн аялгын нөлөөгөөр нэг нэр томьёог авианы ялгаатайгаар дуудаж, бичиж хэрэглэхийг хэлнэ. Их Британи Умард Ирландын Нэгдсэн Вант Улс, Ирланд, Австралид “colour” / Америкийн Нэгдсэн Улс, Канадад “color” гэх жишээтэй. Хам орчны хувилбар нь тухайн нэр томьёо ямар нөхцөлд хэрэглэгдэхээс хамаарна. Тухайлбал зүрхний хэм алдагдлыг англиар анагаах ухааны салбарт “myocardial infarction” бол олон нийтийн хэлний хэрэглээнд “heart attack” гэх нь түгээмэл.

Харин дээр дурдсан “орчин үеийн шинжлэх ухаан”-ыг импортолсон улс, үндэстнүүдийн хэлний хувилбар нэр томьёо энэ дөрвөн төрлөөр үүсдэг ч гол шалтгаан нь гадаад нэр томьёоны хэрэглээ, орчуулга болдог.

Монгол нэр томьёоны тогтолцоонд хувилбар нэр томьёо үүсэх шалтгааныг ийнхүү дүгнэжээ.

О. Адьяа “1. Уугуул үг, ормол үг хоёрыг, эсвэл уугуул үг, улс хоорондын үгийг зэрэг хэрэглэснээс /маркетинг-зах зээл судлал, менежмент-удирдлагын ухаан, бирж-зах, шоу-тоглолт, бизнес-арилжаа, шоу-тоглолт, бизнес-арилжаа наймаа, ломбард-барьцаат зээл, лиги-холбоо, сервис-үйлчилгээ, хобби-дур хорхой г.м/.

2. Ялангуяа шинэ тутам төлөвшиж байгаа салбар ухааны нэр томьёонд орлох нэр элбэг байдаг аж. Жишээ нь: Манай орны хувьд шинэ тутам хөгжиж буй зах зээлийн эдийн засгийн салбарт; /үл үзэгдэх гар-үл үзэгдэх жолоо /невидимая рука/, чамирхлын эрэлт-дуурайх эрэлт/спроссноба/, хөрөнгийн зах зээл-хөрөнгийн бирж/фондовая биржа/шилжих чадвар-хөрвөх чадвар /мобильность/, дуураймал рент-далд рент/квазирент/, эдийн засгийг либералчлах- эдийн засгийг чөлөөлөх/экономический либерализм/ г.м/ орлох нэр өргөн хэрэглэж байна.

3. Хүн хүний мэдлэг, чадвар, дадал, туршилага адилгүй учраас нэг ухагдахууныг өөр өөрийнхөөрөө оносон оноогүй нэрлэдэг том гэм бий. Тухайлбал, “дизайн”-ыг үзэмж /Л.Түдэв/, зохицонгуйн урлаг /Б.Лхагвасүрэн/, ур/Чой. Лувсанжав/, “фен”-ийг шүтэн биширэгч /их төлөв/, даган баясагч /Д. Пүрэвдорж/, “стиль”-ийг урлагт маяг, хэлбэр, /их төлөв/, “донж” /Л.Цогзолмаа/, “тест”-ийг шалгуур, сорил, сорилго, “аудит”-ыг магадлан шинжилгээ, санхүүгийн хяналт, хөндлөнгийн хяналт гэх жишээтэй. Үүнийг хязгаарлан барьж, хазаарлан тогтоох нь нэн чухаг (Адьяа, 2000).

Ц. Өнөрбаян “а/ Олон улсын дундын чанартай нэр томьёог харь хэлнээс аваад монгол нэр томьёогоор тайлбар хийж /ялангуяа шинжлэх ухааны хялбарчилсан зохиолын найруулгад/ хэрэглэснээс хос нэр томьёо үүсээж байна. Энэ нь ихэвчлэн харь хэлний үг монгол үгийн хос байна. Тухайн харь хэлний нэр томьёоны ухагдахуун ойлгомжтой болсон тохиолдолд монгол нэрлэлт орхигдоно. б/ Шинжлэх ухааны тухайн ухагдахуун онолын

үүднээс нарийн шийдвэрлэгдээгүй, маргаантай тохиолдолд түүнийг олон янзаар нэрлэснээс хос нэр томъёо үүсжээ. Тухайн ухагдахууны мөн чанарыг зөв шийдвэрлэсэн үед аль оновчтой нэрлэлт нь үлдэнэ. в/Зарим мэргэжлийн өвөрмөц онцлогоос болж нэг ухагдахууныг зөвхөн мэргэжлийн хүмүүсийн хүрээнд тэмдэглэх нэр томъёо, мэргэжлийн хүмүүсээс бүх нийтэд зориулан хэрэглэх нэр томъёо гэж байдаг. Ийм нэр томъёоны ихэнх нь анагаах ухаан, хими, амьтан, ургамал судлал, эм зүйн нэр томъёоны тогтолцоонд бий. (Өнөрбаян, 1999) гэжээ.

Н. Мөнхцэцэг хувилбар нэр томъёо үүсэх нь хэлний ба хэлний бус хүчин зүйлээс шалтгаалж байна гээд дараах байдлаар ангилжээ.

Хэлний бус хүчин зүйл:

- Тухайн нэрлэгдэж буй юмс үзэгдэл манай улсад байхгүй, шинэ тутам бий болох;
- Орчуулагч, нэр томъёо судлаач, салбарын мэргэжилтнүүдийн хамтын ажиллагаа дутмаг;
- Нэр томъёоны бодлого, тогтолцоо, хяналтгүй байдал;
- Хүн хүний мэдлэг, чадвар, дадал, туршилага харилцан адилгүй;
- Тухайн зохиогчийн танин мэдэхүйн хэв маяг, үзэл баримтлал, дэг сургууль;
- Нэг ухагдахууныг мэргэжлийн хүмүүсийн хүрээнд тэмдэглэх нэр томъёо, мэргэжлийн хүмүүсээс бүх нийтэд зориулан хэрэглэх нэр томъёо гэсэн хувилбартай байх;
- Шинжлэх ухааны тухайн ухагдахуун онолын үүднээс нарийн шийдвэрлэгдээгүй, маргаантай байх гэх мэт багтана.

Хэлний хүчин зүйл:

- Нэр томъёоны тогтолцоот шинжийг үл харгалзах;
- Тухайн гадаад нэр томъёо нь өргөн, олон утгатай байх. Жишээ нь: *notebook*-тэмдэглэлийн дэвтэр, зөөврийн компьютер, өврийн компьютер гэх мэт.
- Нэг ухагдахуун нэрлэсэн нэр томъёог хоёр өөр хэлнээс орчуулах. Тухайлбал, өмнө нь орос хэлнээс нэгэнт орчуулан авсан нэр томъёог англи хэлнээс шинээр орчуулан авсан тохиолдолд хувилбар нэр томъёо үүсэж байна. Жишээ нь: *внебалансовые счета*-балансад ороогүй данс, *off-balance sheet*-балансын гадуурх зүйл /НББ-ийн мэргэжлийн нэр томъёоны толь бичиг/ гэх мэт. Гэтэл орос хэлний *внебалансовые счета*, англи хэлний *off-balance sheet* гэсэн үгс нь угтаа нэг ухагдахуун илэрхийлсэн нэр томъёо юм.
- Гадаад үгийг зээлдэх, монгол үгээр орчуулах хоёрыг хослуулах. Жишээ нь: *arthritis*-артрит, үений үрэвсэл(анагаах ухаан); *innovation*-инновац, эрч шинэчлэл (нийгэм-эдийн засаг); *monitor*-монитор, дэлгэц (мэдээллийн технологи) гэх мэт.

- Монгол хэлэнд шинэ нэр томъёо бүтээхдээ ойролцоо утгатай дагавруудыг хэрэглэх. Жишээ нь: *competence* - чадамж, чадавхи, чадвар; *connection* - холболт, холбоос, холбогч; *correction* - залруулга, залруулалт гэх мэт.
- Нэг ухагдахууныг нэрлэсэн Британийн ба Америкийн англи хэлний хувилбар. Жишээ нь: *mobile phone* (БА) – хөдөлгөөнт утас, гар утас; *cellphone*(АА)-үүрэн телефон; *barrister*(БА)- барристер, өмгөөлөгч, *attorney* (АА)-өмгөөлөгч, хуульч, хуулийн зөвлөх гэх мэт.
- Гадаад нэр томъёог зээлдэхдээ хоёр ба түүнээс дээш хувилбараар галигчлан болон үсэгчлэн буулгах. Жишээ нь: *application* – аппликашн/аппликэйшн/аппликэйшин; *logistic* - логистик/ложистик; *matrix*-матриц/матрикс; *аккруал/аккруэл, андеррайтер/андерайтер* гэх мэт.
- Адилтгал нэр томъёог үгчлэн болон утгачлан орчуулах. Жишээ нь: *daughter company*-охин компани, салбар компани; *bear market*-баавгай зах зээл, ханасан зах зээл гэх мэт.
- Товчилсон үгийн хувилбарт орчуулга. Жишээ нь: *Wi-Fi*- вай фай, утасгүй сүлжээ; *NATO* (*North Atlantic Treaty Organization*)- НАТО, Умард Атлантын Гэрээний Байгууллага; *PR*-Пи-Ар, пиар гэх зэрэг болно (Мөнхцэцэг, 2020).

Мөн тэнд хувилбар бичлэгтэй гадаад үг, нэр томъёоны нийтлэг үзэгдлийг ангилжээ.

- Нэг гадаад нэр томъёог галигчлан болон үсэгчлэн буулгасан. Жишээ нь:
 - *contraband*/ конторбанд/ контрабанд
 - *accrua*l/аккруэль/акруэл/ аккруал
 - *franchise*/ франчайз/ франчиз
- Гадаад, үг нэр томъёоны давхар гийгүүлэгчийг монгол хэлэнд дан, давхар харилцан адилгүй бичсэн. Жишээ нь: *программ/ програм, концесс/ концес, миллиграм/ миллиграм* гэх мэт.
- Гадаад үг, нэр томъёоны эгийг авиаг олон хувилбараар тэмдэглэсэн. Жишээ нь: *gender*-жендер/ жендэр, *merchandise*-мерчедайз/ мерчандайз, *forfeiting*- форфайтинг/ forfeйтинг гэх мэт. Энэ талаар Б.Баяртуяа “Гадаад үгийн зөрүүтэй бичлэгийг жигдлэх асуудалд” өгүүлэлдээ зөрүүтэй бичиж буй үгсийн дийлэнх нь э, е үгсийн зөрүүгээс үүсэж буйг дурдаад, “...англи хэлний “web”-ийг “веб” гэж бичнэ хэмээн журамласан ч “website”-ийг “вэбсайт” хэмээн журамлажээ. Энд нэг л “web” байгаа тул “вэб” эсвэл “веб”-ийн алинаар жигдэлснээ ямар ч тохиолдолд барьж бичих” (2019:108) хэрэгтэйг дурдсан байна.
- Гадаад үг, нэр томъёоны эцсийн зөөлөрсөн гийгүүлэгчийг /и/, /ь/ гэсэн хувилбараар бичсэн. Жишээ нь: *монополь/монополи, магистраль/ магистрал, брайль/брайл, модуль/модул, парсель/парсел, картель/картел, кабел/кабель* гэх мэт.

- Гадаад нийлэмж нэр томъёог салгаж эсвэл нийлүүлж бичих. Жишээ нь: *автомашин/ авто машин, био технологи/ биотехнологи био бэлдмэл/ биобэлдмэл гэх мэт.*
- Хатуу, зөөлний тэмдгийг сольж хэрэглэх. Жишээ нь: *объект/объект, сальмонеллез/сальмонеллез, бульдозер/ бульдозер гэх мэт.*
Гадаад үг, нэр томъёоны өөр нэг асуудал нь европ гаралтай нэр томъёог хоёр өөр хэлнээс авснаас шалтгаалан бичлэг, дуудлага, хэл зүйн хэлбэрийн хувьд өөр байх үзэгдэл юм. (Мөнхцэцэг, 2020) гэжээ.

Эдгээрээс дүгнэвэл, монгол хэлэнд гадаад хэлнээс орж ирсэн нэр томъёо ихэнхдээ урьд өмнө нь Монгол Улсад байгаагүй шинэ тутам ухагдахууныг нэрлэж байгаа бөгөөд тухайн биет болон биет бус зүйлийг ард иргэд хэрэглэн дадахтай зэрэгцэн тэдгээрийг нэрлэсэн нэр томъёо хэвшихэд бас тодорхой цаг хугацаа шаардагддаг нь харагдаж байна. Нэгэнт хэлний хэрэглээнд удаж хэвшсэн нэр томъёоны хувьд хувилбар байх нь учир дутагдалтай бөгөөд аль нэгийг нь сонгон журамлах нь зүйтэй.

4. Стандартчилсан хувилбар нэр томъёо

ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнгийн Хэрэглээний хэл шинжлэлийн салбар, Хэлний бодлогын үндэсний зөвлөлийн Ажлын албатай хамтран Монгол Улсын Засгийн газрын тохируулагч агентлаг Стандарт, хэмжил зүйн газарт бүртгэн стандартчилсан нэр томъёоны өгөгдлийн сангаас Монгол Улсын аж үйлдвэр, нийтлэг үйлчилгээний салбарын 85 стандартын 10387 нэр томъёо, тодорхойлолт бүхий хөмрөг үүсгэн судалгааны хэрэглэгдэхүүн болгон ашиглав. Энэ хөмрөгөөс нэг ухагдахууныг өөр өөрөөр нэрлэсэн хувилбар нэр томъёог түүвэрлэн авч түүнээс хэрэглээ болон хэрхэн жигдлэх, зөв хувилбарыг сонгох, орчуулах талаар авч үзэв.

Хөмрөгт нийт 239 хувилбар нэр томъёо тохиолдох бөгөөд хоёр хэлний буюу гадаад-монгол хувилбар нэр томъёог нь түүвэрлэн авахад 59 нэр томъёо, нэг хэлний буюу монгол хувилбар 180 тохиолдов. Энэхүү хөмрөгт байгаа монгол, гадаад-монгол хувилбар нэр томъёо нь бүгд гадаад үгийн орчуулга, хэрэглээнээс үүссэн байна. Монгол хувилбарын үүссэн гол шалтгаан нь:

1. Уг гадаад нэр томъёоны ухагдахууныг нь гүйцэд судлаагүйгээс хялбарчлан ойролцоо үгсээр хувилбар үүсгэн оноож бүгдийг нь хэрэглэсэн. Жишээ нь:
 - а. Барилга ба иргэний барилга байгууламжийн нэр томъёоны MNS ISO 6701-1: 2010 стандартад “Ус хөндлөн гүйхээс сэргийлсэн доод гадаргуу дахь ухлаадас, гурви” гэсэн тодорхойлолт бүхий “throat” хэмээх нэр томъёог “хонхор”, “ховил”, “ухлаадас”, “гурви” гэсэн хувилбаруудаар оноожээ.
 - б. Барилга ба иргэний барилга байгууламжийн нэр томъёоны MNS ISO 6701-1: 2010 стандартад “Хоёр буюу түүнээс дээш бүтээгдэхүүн, бүрэлдэхүүн,

угсралтууд хамтдаа тавигдан, бэхлэгдэж, нэгдэж байх үед тэдгээрийн зэргэлдээ хэсгүүдээр хэлбэржсэн бүтээц” хэмээх тодорхойлолт бүхий “joint connection” хэмээх нэр томьёог “уулзвар”, “холбоос”, “залгаас холбоос” гэсэн хувилбаруудаар оноосон байна. Гадаад нэр томьёог үгчлэн, утгачлан тус тус орчуулж зэрэгцүүлэн хэрэглэж нэр томьёо оноосон. Жишээ нь:

- a. Мөн стандартад “Том модыг хамтад нь хадахад хэрэглэх, төгсгөлийг шилбэнд тэгш өнцгөөр матсан ба ижил чиглэлд заах, үзүүрлэсэн төгсгөлтэй металл шилбэ” хэмээн бичсэн тодорхойлолт бүхий “iron dog” хэмээх нэр томьёог “хавчуур нохой”, “тогтоогуур” “төмөр хавчуур”, “төмөр нохой” гэсэн 4 хувилбараар орчуулжээ.
- б. Мөн стандартад “Хоёр урсгалтай замын зорчих хэсгүүдийг тусгаарлах зурвас” гэсэн тодорхойлолт бүхий “median reserve” гэх нэр томьёог “хязгаарлах талбай”, “зааглах зурвас”, “хооронд нь тусгаарлах зурвас” гэсэн хувилбаруудаар оноосон байна. Гадаад нэр томьёог монголоор оноосонтой нь зэрэгцүүлэн тайлбар хэлбэрээр нэр оноосон. Жишээ нь:
 - a. Мөн стандартад “hip” хэмээх нэр томьёог “таших шугам” гэж эвтэйхэн оноосонтой зэрэгцүүлэн “дээврийн хажуу” хэмээх тайлбарыг нэр томьёоны үүргээр оруулжээ. Энэ ухагдахуун нь барилгын дээврийн хоёр хавтгайн налж уулзах зааг ажээ.
 - б. Мөн стандартад “carpentry”-г “модон бүтээц” гэж зөв нэр томьёо оноосон байтал давхар “мужааны ажил” гэсэн нэр томьёо оноосон нь тайлбарын шинжтэй болжээ.

Гадаад-монгол хувилбар нэр томьёоны хувьд дараах гурван үндсэн шалтгаанаар үүсжээ гэж хэлж болохоор байна.

1. Орчуулсан монгол үг нь хэлний хэрэглээнд төдийлөн нэвтрээгүй.
2. Монгол Улсын дотор дагаж, мөрдөх бүх нэр томьёог нэгдсэн бодлого, зохицуулалттай боловсруулж хэрэглэх тогтолцоо байхгүй байгаатай холбоотой.
3. Манай ахмад хэл шинжлэлчид ХХ зуунд гадаад улс, орнуудаас орж ирсэн шинэ ухагдахуун, нэр томьёог ард иргэдэд ойлгуулж, таниулах мөн гадаад хэлнээс зээлдсэн үгийг монголоор орчуулах боломжийг давхар эрэлхийлэх үүднээс хувилбар үүсгэж хэлний хэрэглээний аясаар уралдуулдаг тал байсан бололтой.

5. Стандартчилсан гадаад-монгол хувилбар нэр томьёо

Хөмрөгт буй нэг ухагдахууныг монгол болон гадаад хэлээр давхар оноосон 59 хувилбар нэр томьёоноос хамгийн их буюу 26 нь “Барилга ба иргэний барилга байгууламжийн салбар”-г байгаа бол хамгийн бага нь нэхий эдлэл ба түүний эд ангийн нэр томьёонд 1 байна. Эдгээр 59 нэр томьёог салбаруудаар нь хүснэгтлэн харьцуулбал:

Хүснэгт 1. Гадаад-монгол хувилбар нэр томъёоны тоон үзүүлэлт салбаруудаар

№	Стандартын нэр	Салбар	Гадаад-монгол хувилбар нэр томъёо
1	MNS ISO 6701-1: 2010	Барилга ба иргэний барилга байгууламж	26
2	MNS 0515: 2015	Шуудан холбоо	11
3	MNS ISO 2392-1: 1999	Мэдээллийн технологи	3
4	MNS ISO/TS 19104: 2012	Газар зүйн мэдээлэл	3
5	MNS ISO 1998-2: 2008	Газрын тосны бүтээгдэхүүний физик, химийн шинж чанарын үзүүлэлт	2
6	MNS ISO 1998-6: 2008	Газрын тосны аж үйлдвэр, хэмжилт	2
7	MNS 4118: 1991	Хөдөө аж ахуй. Ойн аж ахуй	2
8	MNS 5242: 2003	Нягтлан бодох бүртгэл	2
9	MNS 5086: 2001	Зуухны эд анги, хэсэг. Эрчим хүч ба дулаан дамжуулах техник	1
10	MNS ISO 1998-1: 2008	Дунд зэргийн зууралдлагатай бүтээгдэхүүн, тосолгооны материал болон энэ төрлийн бүтээгдэхүүн	1
11	MNS 6387-1: 2013	Төмөр зам. Зам. Замын аж ахуй	1
12	MNS 3843: 1985	Нэхий эдлэл ба түүний эд анги	1
13	MNS ISO 9229: 2010	Дулаан тусгаарлах материал	1
14	MNS ISO 7967-1: 2000	Дотоод шаталтын хөдөлгүүр, бүтцийн суурь эд анги	1
15	MNS ISO 3877-1: 2014	Резин дугуй, хийлэх хошуу	1
16	MNS 5914: 2008	Байгаль орчин. Эвдэрсэн газрын нөхөн сэргээлт	1

Онолын хувьд монголын уламжлалт шинжлэх ухаан, мэргэжлийн салбараас илүүтэйгээр хөгжиж буй салбарт гаднаас шинэ мэдлэг, бүтээгдэхүүн, үйлчилгээ ихээр орж ирэх, түүнийг дагалдаад тэдгээр салбарт гадаад-монгол хувилбар нэр томъёо их байх магадлалтай. Харин дээрх хүснэгтээс ажиглахад энэхүү стандартчилсан нэр томъёоны сангийн хувьд салбаруудын гадаад-монгол хувилбар нэр томъёо их, бага байх эсэх нь стандартчилсан огнооноос, хэрэглээний хамрах хүрээ түүний дагалдсан нэр томъёоны сангийн нөөцийн их багаас бас хамаарч байна. Тухайлбал хамгийн их буюу 26 гадаад-монгол хувилбар нэр томъёотой MNS ISO 6701-1: 2010 стандарт бүхий “Барилга ба иргэний барилга байгууламж”-ийн нэр томъёоны хэрэглээ түгээмэл бол хамгийн цөөн буюу 1 гадаад-монгол хувилбар нэр томъёотой салбаруудын нэг болох “Дунд зэргийн зууралдлагатай бүтээгдэхүүн, тосолгооны материал болон энэ төрлийн бүтээгдэхүүн”-ийн нэр томъёоны хэрэглээ нь олон нийтийн дунд

түгээмэл бус, газрын тосны мэргэжилтэн, химичдийн хүрээгээр хязгаарлагддаг. Мөн онолын хувьд харьцангуй их гадаад нэр томьёотой үүнээс улбаалаад хувилбар их гарах магадлалтай “Мэдээллийн технологи”-ийн салбарын гадаад-монгол хувилбар нэр томьёо 3 байгаа нь тун цөөн байна. Үүний шалтгаан нь тус салбарын нэр томьёог стандартчилсан 1999 онд мэдээллийн технологийн салбар нь өөрөө Монгол Улсад хөгжөөгүй гарааны үедээ байсан гэж хэлж болно. Түүнээс хойш өдгөө хүртэл буюу 2024 оны байдлаар тус салбарт шинэ мэдлэг түүнийг дагалдсан нэр томьёо маш ихээр орж ирсэн байдаг. Мэдээллийн технологийн салбарын нэр томьёог сүүлийн үеийн байдлаар дахин жигдлэн стандартчилбал дээрх гадаад-монгол хувилбар нэр томьёоны тоо хэд дахин нэмэгдэж гарч ирэх магадлалтай. Энэ хүснэгт дэх MNS 3843: 1985 “Нэхий эдлэл ба түүний эд анги”-ийн нэр томьёоны санд гадаад-монгол хувилбар нэр томьёо ганцхан байгаа нь нэг талаар энэ салбар монголчуудын уламжлалт ажил мэргэжилтэй холбоотой учраас шинэ ухагдахуун гаднаас бага орж ирсэн үүнийг нэрлэх уугуул нэр томьёо, ажил мэргэжлийн үг, нэршил монгол хэлэнд хангалттай байдагтай холбон тайлбарлаж болох бол нөгөө талаас 1985 онд стандартчилсан нь түүнээс хойш нэмэгдсэн нэр томьёо байхгүйгээс болжээ. Эдгээрээс дүгнэхэд, огноо нь хуучирсан стандартын нэр томьёоны сангууд одоо үед монгол хэлний нэр томьёоны тогтолцооны өнөөгийн байдлын талаар судалгаа, шинжилгээ хийхэд хэрэглэгдэхүүний шаардлага хангахгүй бөгөөд тэдгээрийг дахин сүүлийн үеийн байдлаар жигдлэн, журамлаж стандартчилах шаардлагатай болсон нь харагдаж байна.

Бид энэхүү судалгаандаа зарим салбарын нэр томьёоноос зөв хувилбарыг сонгох, жигдлэх боломжийн талаар өөрийн саналыг тусгав. Тухайлбал, MNS 3843: 1985 *Нэхий эдлэл ба түүний эд анги-д комбинзон-ыг бадай* гэж оноосон нь хуучирсан үгээр нэр томьёо оноох зарчмыг хэрэглэсэн оновчтой, товч болсон бөгөөд утга яв цав дүйхгүй боловч орлуулж болохуйц болжээ. Гадаад нэр томьёог хуучин үгээр оноох нь идэвхгүй үгийн сангийн нөөцийг хэлний хэрэглээнд дахин оруулж, шинэ үүргээр сэргээн хэрэглэх, хэлний үгийн санд гадаад үг олшрохоос хамгаалах сайн талтайг бид бүгд мэдэх билээ. *Бадай* гэх нэр томьёо *комбинзон-ыг* орлож хэлний хэрэглээнд нэвтрээгүйгээс гадна одоо олон нийтийн дунд мартагдсан энэ үгийг хэл шинжлэлчид дотор ч мэдэх нь хуруу дарам цөөн байна.

Я.Цэвэлийн “Монгол хэлний товч тайлбар толь”-оос энэ үгийг хайхад олдсонгүй. ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнгээс гаргасан “Монгол хэлний их тайлбар толь”-ийн цахим хувилбарт: “*Өмд цамцыг үргэлжид нь хийсэн гадуур өмсөх хувцас, комбинзон*” гэсэн бол мөн тус хүрээлэнгээс 1992 онд гаргасан “Монгол хэлний сувд эрих нэрт ховор үгийн толь”-д: “*Хагархай салтаатай хүүхдийн өмд*” гэжээ. Тиймээс эхний утгаар хэрэглэж болох юм.

MNS 6387-1: 2013 *Төмөр зам. Замын аж ахуй* стандартад *хонпер-ыг* тус нэр томьёоны хөмрөгт тодорхойлохдоо: “*Төмөр замын техникийн үйлчилгээ ба барилгын ажил явуулахад шаардагдах чигжээсийг тэгшлэх ба тугнах механик*

аргаар буулгах, зам хооронд тавих, тээвэрлэх зүтгүүрийн хүчээр шилжин явдаг тээврийн хэрэгсэл” гэжээ.

Төмөр замын тээврийн хэрэгслийн ангилал дотор нунтаг эсвэл ширхэглэг ачааг задгайгаар тээвэрлэн хүндийн хүчээр ёроолоос нь урсган буулгах зориулалтай гурвалжин хэлбэрийн вагоныг *хонпер вагон* гэж нэрлэдэг.

Хонпер нь англи хэлний *hopper* гэх үгээс гаралтай бөгөөд толиудад тайлбарласнаас дурдвал: *Хоёр үзүүрийнх нь нэг нь өргөн нөгөө нь нарийн урт том хоолой. Их хэмжээний үр, буудай, малын тэжээл мэт ширхэглэг зүйлсийг нэгээс нөгөө рүү дамжуулан ачих буулгах зориулалтай төхөөрөмж*⁹

*Будаа, малын тэжээл, нүүрс мэт ширхэглэг зүйлсийг агуулсан V хэлбэртэй чингэлэг. Эдгээрийг тээвэрлэхдээ ёроолоос нь урсгаж юүлэн авдаг*¹⁰.

*Конус хэлбэртэй овортой төхөөрөмж. Нүүрс, үр, тариа мэт зүйлсийг дотор нь хийгээд хэрэгтэй үедээ урсган авдаг*¹¹ гэх мэтээр тодорхойлжээ.

Тугнах, тугнуур гэсэн үгсийг монгол хэлний тайлбар толиудаас хайвал:

Тугнах - Эмийг тунгаар хэмжих: тугнаж үзэх (тунгаар үзэх), тугнаж хэмжих (тунгаар хэмжиж үзэх), эм тугнах (эмийг тунгаар бэлдэх)

*Тугнуур - Тунгийн халбага, талхан эмийг хэмжих бяцхан халбага: тугнуураар хэмжих (тунгийн халбагаар хэмжих)*¹².

*Тугнах – Эмийг тун тунгаар болгох, тугнуураар хувааж хэмжих*¹³

*Тугнуур – Тунгийн халбага, талхан эмийг хэмжих бяцхан халбага*¹⁴ гэсэн байна.

Тэгэхээр *хонпер*-ыг *тугнуур* хэмээх хуучин монгол үгийг сэргээн нэрлэсэн нь утга бүрэн дүйж мөн нэр томъёо оноох зарчимд нийцсэн байна. Иймээс төмөр замын салбарт *хонпер*-ыг *тугнуур*, *хонпер вагоныг тугнуур вагон, тугнуур чингэлэг* гэж нэрлэн хэвшүүлэх нь зүйтэй.

Хүснэгт 2. Барилга ба иргэний барилга байгууламжийн салбарын хувилбар нэр томъёо

Стандартын нэр: MNS ISO 6701-1:2010		
№	Гадаад хувилбар	Монгол хувилбар
1	Насос	Хөөрөг
2	Крант	Хаалт
3	Гель	Нунжгай
4	Энерги	Эрчим

⁹ <https://dictionary.cambridge.org/dictionary/english/hopper>.

¹⁰ https://www.oxfordlearnersdictionaries.com/definition/american_english/hopper

¹¹ <https://www.collinsdictionary.com/dictionary/english/hopper>

¹² https://www.mongoltoli.mn/search.php?opt=1&ug_id=89217

¹³ Я.Цэвэл, (1966). *Монгол хэлний товч тайлбар толь. Улаанбаатар*: Улсын хэвлэлийн хэрэг эрхлэх хороо. х.554.

¹⁴ Я.Цэвэл, (1966). *Монгол хэлний товч тайлбар толь. Улаанбаатар*: Улсын хэвлэлийн хэрэг эрхлэх хороо. х.554.

5	Каркас	Араг бүтээц
6	Рам	Араг бүтээц
7	Кронштейн	Тулгуур
8	Веранд	Үүдний задгай гонх
9	Фасад	Нүүрэн тал
10	Кабель	Татлага, ган дээс

Барилга ба иргэний барилга байгууламжийн салбарын стандартчилсан нэр томъёоноос гадаад хувилбараа бүрэн орлож чадах нь эдгээр *хөөрөг, хаалт, нунжсгай, тулгуур* хэмээх нэр томъёо юм. Хэлний хэрэглээний идэвхийг нь гадаад хувилбартай нь харьцуулбал (барилга ба иргэний барилга байгууламжийн салбарт):

Тулгуур > Кронштейн

Хөөрөг < Насос

Нунжсгай < Гель

Хаалт < Крант

Кабель-ийг *татлага, ган дээс* гэж хоёр монгол хувилбартай хамт хэрэглэсэн байна.

Кабель нь бас цахилгаан дамжуулах бүрмэл металл утсыг ч илэрхийлдэг. *Рам, каркас* хоёрыг хоёулыг нь *араг бүтээц* гэж нэрлэсэн нь давхардал үүсгэснээс гадна оновчгүй болжээ. Өнөө цагт *каркас*-ыг барилгын салбарт *араг бүтээц* гэж нэрлэх нь түгээмэл бол *рам*-ыг *хүрээ* гэж орчуулдаг.

Фасад нь англи хэлний “facade” хэмээх үгээс гаралтай. Мериам Вебстер толь бичигт: *Барилгын нүүрэн тал*, Коллинс толь бичигт: *Барилгын нүүрэн тал эсвэл гудам руу харсан тал* гэсэн нь энд монголоор оноосон *нүүрэн тал* гэсэн нэр томъёотой утга дүйж байгаа боловч *фасад* хэмээх нэр томъёогоор Монгол Улсын барилгын салбарт зөвхөн *нүүрэн тал* биш барилгын гадна талын өнгөн хэсгийг бүхэлд нь нэрлэдэг. Жишээ нь: Хэвлэл, мэдээллийн хэрэгслээр “*фасадын ажил хийлгэнэ*” гэх зар явж байвал зарын дагуу очсон хүмүүс барилгын гадна талыг бүхэлд нь хамарсан өнгөлгөөний ажил хийсэн байдаг. Тэгэхээр барилгын салбарт *фасад*-ыг *гадар, фасадын ажил*-ыг *гадрын ажил* гэж нэрлэх нь зүйтэй болов уу.

MNS ISO/TS 19104: 2012 *Газар зүйн мэдээлэл. Мэдээллийн технологи албан ажлын техник хэрэгсэл* стандартад *изоморфизм*-ыг *ижил хэлбэрт дүрстэй* гэсэн нь үг илүүдсэн, тайлбарын шинжтэй, найруулгын алдаатай болсон байна. Харин *ижил хэлбэр* гэвэл тохиромжтой. Полиморфизм-ыг *олон хэлбэрт* гэсэн нь утгын болон нэр томъёо оноох зарчмын хувьд таарч байгаа ч үг зүйн хувьд *олон хэлбэр* гэвэл зөв болно.

Мөн MNS ISO 9229: 2010 *Дулаан тусгаарлах материал* стандартад *Полиэстер*-ийн монгол хувилбар нь *Утаслаг ширхэглэлтэй дулаалгын материал* гэж байгаа нь нэр томъёо биш тайлбар болсон байна. Газрын тосны дайвар

бүтээгдэхүүнээс гаргаж авсан синтетик буюу нийлэг бүтэцтэй ийм төрлийн материалыг хими технологийн олон улсын нэр томьёогоор нь нэрлэх нь зүйтэй болов уу. Харин бичлэгийн хувьд монгол хэлний авиа зүйн онцлогт тааруулан *полистер* гэж бичих нь тохиромжтой гэж үзэж байна.

6. Дүгнэлт

ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнгийн Хэрэглээний хэл шинжлэлийн салбар, Хэлний бодлогын үндэсний зөвлөлийн Ажлын албатай хамтран Монгол Улсын Засгийн газрын тохируулагч агентлаг Стандарт, хэмжил зүйн газарт бүртгэн стандартчилсан нэр томьёоны өгөгдлийн сангаас Монгол Улсын аж үйлдвэр, нийтлэг үйлчилгээний салбарын 85 стандартын 10387 нэр томьёо, тодорхойлолт бүхий хөмрөг үүсгэн судалгааны хэрэглэгдэхүүн болгон хэрэглэв. Энэ хөмрөгөөс нэг ухагдахууныг өөр өөрөөр нэрлэсэн хувилбар нэр томьёог түүвэрлэн авч түүнээс хэрэглээ болон хэрхэн жигдлэх, зөв хувилбарыг сонгох, орчуулах талаар авч үзэв. Хөмрөгт нийт 239 хувилбар нэр томьёо тохиолдох бөгөөд хоёр хэлний буюу гадаад-монгол хувилбар нэр томьёог нь түүвэрлэн авахад 59 нэр томьёо, нэг хэлний буюу монгол хувилбар 180 тохиолдов. Энэхүү хөмрөгт байгаа монгол, гадаад-монгол хувилбар нэр томьёо нь бүгд гадаад үгийн орчуулга, хэрэглээнээс үүссэн байна.

Гадаад нэр томьёо тогтмол орж ирж буй энэ үед манай улсын нэр томьёоны салбар тэдгээрийг орчуулах, боловсруулах, оноох албан ёсны стандарт, баримтлах зарчимгүй явж байна. Монгол Улс дахь нэр томьёоны стандарт гэдэг нь бодит байдал дээр тухайн салбаруудаас ирүүлсэн нэр томьёоны жагсаалтын бүртгэл төдий зүйл болох нь анзаарагдав. Иймээс нэр томьёо боловсруулах, оноох, батлахдаа олон улсын ISO стандартад нийцүүлэх нь зүйтэй. Мөн нэр томьёог гадаад, монгол аль нэгээр нь оноон тогтооход дагаж мөрдөх тодорхой стандартыг бий болгох шаардлагатай болжээ гэж хэлж болохоор байна.

Ном зүй

- Адьяа, О. (2000). Нэр томьёог оноон тогтоох үндсэн зарчим, арга хэлбэр, *Нэр томьёо судлал сэтгүүл, Боть III*, 15-23 [Адьяа, О. Basic principles and methods of creating terms, *Ner tomyo sudlal*, 2000, 3:15-23.]
- Амаржаргал, Б., Балдан, Л., Сэржээ, Ж., Тунгалаг, Ө., Янжиндолгор, А. (1992). *Монгол хэлний сувд эрх нэрт ховор үгийн толь*. Улаанбаатар. Шинжлэх Ухааны Академийн хэвлэх цех. [Amarjargal, B., Baldan L., Serjee J., Tungalag U., Yanjindolgor, A. *Mongol khelnii suvd erikh nert khovor ugiin toli*. [Pearl bead of Mongolian language the dictionary of rare words] Ulaanbaatar: Printing house of Mongolian Academy of Sciences. 1992]
- Балдан, Л. (2002). Нэр томьёог ухагдахууны утгаар тогтоох нь, *Нэр томьёо судлал сэтгүүл, Боть V*, 9-14 [Baldan, L. Creating terms in semantics of concepts. *Ner tomyo sudlal*, 2002, 5:9-14.]

- Балдан, Л.** (2017). *Монгол хэл, нэр томьёо найруулга зүйн судалгаа*. Улаанбаатар. Соёмбо принтинг. [Baldan, L. *Mongol khel, ner tomyo nairuulga zuin sudalгаа*. [Mongolian language, terminology and semantics]. Ulaanbaatar: Soyombo printing. 2017.]
- Болд, Л.** (2001). Нийгмийн шинжлэх ухаанд хэрэглэж буй зарим нэр томьёо, *Нэр томьёо судлал, Боть IV*, 31-37 [Bold, L. Some terms used in Social Science. *Ner tomyo sudlal*, 2001, 4:31-37.]
- Болд, Л.** (2009). Техник, технологийн нэр томьёог боловсронгуй болгох хэл шинжлэлийн шаардлагууд, *ХБС-ийн ЭШБ, Боть I* [Bold, L. Linguistic requirements for the processing of technical and technological terms. Research papers of School of Language education, 2009, 1: 4-10.]
- Бямбажав, П.** (2020). Монгол хэлний нэр томьёо дахь орлох нэрийн судалгаа (Барилгын салбарын жишээгээр), *Докторын диссертаци* [Byambajav, P. A research of substitute nouns in Mongolian terminology. *Barilgiin salbariin jisheegeer Doctoriin dissertatsi* 2020.]
- Лувсанвандан, Ш.** (1962). Орчин цагийн монгол хэлний үгсийн сангийн зарим асуудал. *МУИС-ийн ЭШБ. VI боть*, 10 [Some issues of modern Mongolian vocabulary. *MUIS-iin erdem shinjilgeenii bichig VI boti* 1962, 6:10]
- Мөнхцэцэг, Н.** (2020). *Нэр томьёоны орчуулга судлал*. Улаанбаатар. Соёмбо принтинг. [Munkhtsetseg, N. *Ner tomyonii orchuulga sudlal*. [Translation of terminology]. Ulaanbaatar: Soyombo printing. 2020.]
- Өнөрбаян, Ц.** (1999). Шинжлэх ухааны нэр томьёог журамлах тухай асуудалд, *Нэр томьёо судлал, Боть II*, 5-12 [Issue of regulating science terms, *Ner tomyo sudlal, boti II*, 2: 5-12.]
- Пүрэвжав, Э.** (1996). *Монгол хэлний хэм хэмжээ*. Улаанбаатар. Admon. [Purevjav, E. *Mongol khelnii khem khemjee*. [Mongolian language norm]. Ulaanbaatar. Admon. 1996.]
- Томтогтох, Г.** (2014). Техник, технологийн нэр томьёог боловсронгуй болгоход ШУТИС-ийн гүйцэтгэх үүрэг, *Монгол нэр томьёо судлал-90*, 158-165 [Role of Mongolian University of Science and Technology in harmonizing technical and technological terminology. *Mongol ner tomyo sudlal-90*: 158-165.]
- Цэвэл, Я.** (1966). *Монгол хэлний товч тайлбар толь*. Улаанбаатар. Улсын хэвлэлийн хэрэг эрхлэх хороо. [Tsevel, Ya. *Mongol khelnii tovch tailbar toli*. [Brief dictionary of Mongolian language]. Ulaanbaatar: State committee of printing affairs. 1966.]
- Энхжаргал, С.** (2014). Нэр томьёог хэвшүүлэхэд сурах бичгийн үүрэг, *Монгол нэр томьёо судлал-90*, 167-174 [Role of textbooks in harmonizing terms. *Mongol ner tomyo sudlal -90*: 167-174.]
- B'eatrice Daille, Beno'it Habert, Christian Jacquemin, Jean Royaut.** (2000). Empirical Observation of Term Variations and Principles for their Description, France. Paris. Paris University Press.
- Geoffrey Finch** (1999) Linguistics Terms and Concepts. New York. St.Martin's Press.
- John Lyons.** (1977). Semantics, Cambridge, Cambridge University Press.
- Loreto Todd.** (1989). The Language of Irish Literature. UK. London. Publisher Macmillan

Education.

Melania Cabezas-García, Pilar León Araúz. (2020). Term variation in terminographic resources: a review and a proposal, *Proceedings of the 12th Conference on Language Resources and Evaluation*, pp 2358–2367

Miguel Ángel Candel Mora, María Luisa Carrió Pastor. (2013). Variation in the translation patterns of English complex noun phrases into Spanish in a specific domain, *Journal Languages in Contrast*. pp 34-46

Цахим сурвалж

https://www.mongoltoli.mn/search.php?opt=1&ug_id=89217

<https://dictionary.cambridge.org/dictionary/english/hopper>

https://www.oxfordlearnersdictionaries.com/definition/american_english/hopper

<https://www.collinsdictionary.com/dictionary/english/hopper>

Стандарт

ISO 860: 2007 *Terminology work - Harmonization of concepts and terms*

ISO 1087: 2019 *Terminology work and terminology science — Vocabulary*



Open access: This is an open access article distributed in accordance with the Creative Commons Attribution Non-Commercial (CC BY-NC 4.0) license, which permits others to distribute, remix, build upon this work non-commercially, and license their derivative works on different terms, provided the original work is properly cited, appropriate credit is given, any changes made indicated, and the use is non-commercial. See: <http://creativecommons.org/licenses/by-nc/4.0/>.